



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 09-р сарын 23-ны өдөр

Дугаар 22-02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 14:00 цагт ХУД-ийн 2-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Энэхүү ээлжит бус хурлыг Булигаар ХК-ийн ТУЗ-ийн дарга А.Энхмэнд даргалж, ТУЗ-ийн гишүүд болон Хувьцаа эзэмшигч нар оролцов.

Хурлын дарга А.Энхмэнд: Та бүхний амар амгаланг айлтгая. Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022.09.23-ны өдөр болж болно. Энэхүү хурлаар гол хэлэлцэх асуудлууд нь хурлын ирцийг бүртгэсний дараа танилцуулах байгаа. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмааг ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа: Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийг мэдээлье. Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 400,212,000 бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 145,996,000 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 206,630,000 саналын эрхтэй нийт 2 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт хурлын ирц 88.1% болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг хуралд оролцогчид болон Хурлын даргад мэдээлсүгэй.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга А.Энхмэнд: Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаад баярлалаа. Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хуурлын ирц шаардлага хангаж байгаа учир хурлаа албан ёсоор нээж байгааг мэдэгдэж байна. Хурлын дэгийг товч танилцуулахад Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна. Дараа нь хэлэлцэх асуудлын дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт өгнө. Санал хураалт явагдана. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулаад тогтоолын төслийг бидэнд танилцуулна. Үүнээс гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, санал авч шийдвэр гаргах байгаа.

- 1-рт. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гүйлгээнд гаргах тоог тогтоох, ТУЗ-д эрх олгох

2-рт. Компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ батлах, хувьцааны тоог тогтоох, эдгээр 2 асуудлаар хуралдах гэж байгаа. Та бүхэнд ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат танилцуулах бөгөөд уг асуудлуудыг хэлэлцэн санал авна.

ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Одоо Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулъя. “Булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2022 оны 08-р сарын 12-ны өдрийн 18/22 тоот тогтоолоор Тооллогын комисс нь томилогдсон бөгөөд тооллогын комиссын даргаар Ю.Дүгэрмаа /Дархан минж ХХК-ийн нарийн бичиг/ гишүүдээр Д.Энхзул /Булигаар ХК-ийн нярав/, Б.Саруул /Лугати ХХК-ийн нягтлан бодогч/ гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон ажиллаж байна. Тооллогын комисст томилогдсон хүмүүс маань өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд бус гэдгийг онцолж хэлье.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ:

1-рт. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гүйлгээнд гаргах тоог тогтоох, ТУЗ-д эрх олгох

ТУЗ-ийн хараат бус Ж.Эрдэнэбат: Ерөнхийдөө компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах тухай гэдэг эхний хэлэлцэх асуудлыг өмнөх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Булигаар хувьцаат компанийн хувьцааг 400,212 хуваагаад 400,212,000 (дөрвөн зуун сая хоёр зуун арван хоёр мянга) ширхэг хувьцаа болгосон. Нөгөө нь тодорхой тооны хувьцааг зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргаад компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн сайжруулах тогтоол гаргасан боловч СЗХ-оос хурлын материалтай танилцаад хувьцаа нэмж гаргах асуудлыг хойшлуулагдах болох нь тэрийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх зөвлөмж өгсөн. Энэ удаа бол хувьцааг чинь хуваагаад 400,212,000 болгож баталсан байгаа өөрчлөлтийг СЗХ дүрэмд орсон өөрчлөлтийг зөвшөөрсөн учраас Булигаар ХК-ийн хувьцааг 400,212,000 ширхэг байхаар тогтоогоод нэмж хувьцаа гаргах асуудлыг дахин хэлэлцэх чиглэл өгсөн. Энэ асуудлыг дахин хэлэлцэн компани нэмж хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татаж, технологийн шинэчлэл хийх зорилгоо хэвээр хадгалж байгаа учраас энэ саналаа ээлжит бус хурлаараа хэлэлцүүлье гээд 9-р сарын 23-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах, хуралдуулах тогтоолыг ТУЗ-өөс гаргасан. Үүний дагуу энэ асуудлыг оруулж ирж байна. Энэ асуудлын хүрээнд 1-р компанийн тухай хуулийн 31.2 дахь заалт, 33.3 дахь заалт, 62.1.3 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7.7.3 заалтаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн нэмж гарах хувьцааны тоог тогтоож өгөх гэсэн заалтын хүрээнд гаргаж байгаа энэхүү тогтоолын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нэмж гүйлгээнд гаргах энгийн хувьцааг бол зарласан хувьцаанаас 140,000,000 хүртэлх хувьцааг гүйлгээнд гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрөөд, гүйлгээнд нэмж гаргах энгийн хувьцааны тоо, нийтэд санал болгох үнэ, хугацаа, хувьцаа нэмж гаргахтай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэж ажиллахыг ТУЗ-д даалгасан тогтоол гаргаж байгаа. 140,000,000 хүртэлх

хувьцаа гаргаж байгаа нь 140,000,000, 135,000,000, 130,000,000 гэсэн яг эцсийн олон нийтэд гаргах тоог ТУЗ-д тогтооно. Нэгж хувьцааг хэдэн төгрөгөөр гаргах уу 30, 40 төгрөгөөр гаргах гэдгийн ТУЗ-д тогтооно. 2022 он гаргах уу 2023 оны 1,2-р улиралд гаргах уу гэдгийг ТУЗ-өөр хэлэлцэх зөвшөөрөл өгч байгаа учир ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ. 1-р хэлэлцэх асуудал бол компанийн зарласан энгийн хувьцаанаас 140,000,000 хүртэлх хувьцааг нэмж гаргах тоог тогтоож өгч байгаа юм. Энэхүү асуудлын хүрээнд саналтай, асууж тодруулах хувьцаа эзэмшигч байна уу.

Хурлын дарга А.Энхмэнд: Байхгүй байна.

ТУЗ-ийн хараат бус Ж.Эрдэнэбат: Энэ асуудал дээр танилцсан гээд ойлголоо.

2-рт. Компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ батлах, хувьцааны тоог тогтоох

ТУЗ-ийн хараат бус Ж.Эрдэнэбат: 2 дахь хэлэлцэх асуудал гэвэл, миний бие Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, бид нар гүйцэтгэх удирдлага болон ТУЗ дээр ярилцаад ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр буюу ESOP хөтөлбөр баталъя гэж ярилцсан. Тэрний дагуу төсөл хөтөлбөр дагуу ерөнхий зарчмаа ярилцаад хувьцаа эзэмшигчдийн хуралд дээр оруулж ирж байгаа 1-рт асуудал нь: ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх сан хэлбэртэй байх юм байна. Тэр сангаа байгуулъя, 2-рт сангийн ажиллах дүрэм, журмыг ТУЗ-д боловсруулаад, хэлэлцэж батлах асуудлыг ТУЗ-д даалгах, 3-рт ажиллагсад сангийн хувьцаа эзэмшүүлснээр хамааран ажилтнуудын KPI буюу хөдөлмөр оролцооны коэффициентын урамшууллын үнэлгээг хэрхэн яаж, ямар аргачлалаар тогтоохыг гүйцэтгэх удирдлага боловсруулаад ТУЗ-д оруулж батлуулах үүрэг даалгавар өгөх тогтоол баталж байгаа юм. Яг хувьцааны тооноос хичээн хувьцааг санд эзэмшүүлэх вэ гэдэг асуудал яригдах байсан боловч ТУЗ-ийн өмнөх хуралд ярилцсанаар ажиллагсдын санд хувьцаа эзэмшүүлэхдээ давуу эрхийн хувьцааг эзэмшүүлье гэсэн. Давуу эрхийн хувьцаа бол заавал ногдол ашиг авч байдаг. Үйл ажиллагаанаас санд ногдол ашиг өгч байдаг сангаас заавал ажилтнуудыг урамшуулж байдаг. Давуу эрхийн хувьцаа байя гэсэн асуудал дээр тохиролцсон.

Энэ удаа давуу эрхийн хувьцааг дүрэмд заагаагүй учраас гүйлгээнд гаргах боломжгүй учраас сангаа байгуулчихъя, үйл ажиллагааны журмыг ТУЗ-өөс боловсруулаад батлуул, үнэлгээ нь яаж, ямар аргачлалаар ажилтнуудыг урамшуулахыг аргачлалаа боловсруулаад ТУЗ-д оруулж батлуулах гэсэн үүрэг бөгөөд ирэх оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд давуу эрхийн хувьцаа оруулж давуу эрхийн хувьцааг гүйлгээнд оруулаад, хэдийг нь санд өгөхийг цаашид ашгаа яаж хуваарилж явахыг нь хэлэлцье гээд 2 дахь хэлэлцэх асуудлын хүрээнд хөтөлбөрөө баталчихъя, хөтөлбөрийн ерөнхий танилцуулгыг оруулаад ирсэн байгаа.

Тэгээд сангаа байгуул, хөтөлбөрт хамрагдаж ямар урамшууллын аргаар ажилтнуудаа урамшуулах аргачлалыг боловсруулахыг гүйцэтгэх удирдлагад даалгаж ТУЗ-өөр батлуулах. Ерөнхийдөө сангийн тухай танилцуулахад ажилтнуудад энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшүүлэх замаар урамшууллын хэлбэр байдаг. Гэхдээ сан байгуулдаг нь төсөл дээр итгэмжлэлийн сан гэсэн ажиллагсдын нийгмийн хамгааллын сан байгуулаад тэр санд давуу эрхийн хувьцаа авна. Гэхдээ сан давуу эрхийн хувьцаа өгөөд оруулдаг нэг хэсэг санд тодорхой хэмжээний мөнгө өгөөд буцаагаад давуу юм уу, энгийн эрхтэй хувьцаа авдаг арга байдаг. Энд оруулж ирж байгаа саналын хувьд он гараад

сандаа компаниас мөнгө хийнэ. Давуу эрхийн хувьцаа гаргахаар сан худалдан аваад цаашид процесс нь явахаар болсон байгаа.

Үүний гол зорилго нь ажилтнууд өөрсдөө компанийн бизнес процесст тогтвор суурьшилтай итгэл үнэмшилтэй асуудлыг компанийн үйл ажиллагааг тогтвортой байлгах, компанийн хүний нөөцийг тогтвортой байлгах гэсэн үүднээс гарч байгаа асуудал юм. Энэхүү хөтөлбөрт Булигаар ХК-ийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс бусад ажилтнууд хамрагдах гэдгээр байгаа. Сан байгуулаад сандаа компанийн давуу эрхийн хувьцааг сандаа эзэмшүүлнэ. Нийт ажилтан албан хаагч нь сангийн хувьцаа эзэмшинэ гэсэн үг. 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан хүн бол сангийн хувьцааг дараа худалдах эсвэл сандаа байгаад сангийн эзлэх хувьцааны хувиасаа хамааран урамшууллаа авч болохоор тооцоолол хийсэн байгаа.

Санд байгуулснаар ажилтнуудад чиглэсэн урамшууллаас гадна нийгмийн хамгаалал руу чиглэсэн олон хөтөлбөр төслийг санхүүжүүлэх боломжийг бий болгох юм. Энэ удаа компанийн дүрэмд давуу эрхийн хувьцаа байгаагүй учраас санд хэдэн хувьцааг өгөх асуудлыг шийдвэрлэж чадахгүй гэхдээ ийм зорилгоор хөтөлбөр баталж байгаа шүү. ажилтнуудад давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэх байгаа шүү гээд сангаа байгуулах сангийн үйл ажиллагааны журам гаргаж батлах, санд компаниас оруулах хөрөнгийн хэмжээг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосон байгаа.

Энэхүү асуудлын хүрээнд саналтай, асууж тодруулах хувьцаа эзэмшигч байна уу.

Хувьцаа эзэмшигч: энгийн хувьцаа өгөхгүй гэсэн үү?

ТУЗ-ийн хараат бус Ж.Эрдэнэбат: Танилцуулга дээр энгийн болон давуу эрхийн хувьцаа гэж байгаа гэхдээ нийт ажилтнуудад олгох хувьцааг давуу эрхийн хувьцаа гэж тохиролцсон байгаа. Зарим нэг топ менежерийн түвшинд цаашдаа энгийн хувьцааны асуудал яригдаж магадгүй гэсэн үүднээс төсөл дээрх хөтөлбөрт бол энгийн болон давуу эрхийн хувьцаа гээд оруулаад явах нь зүйтэй гэж үзсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч: Тогтоолын төсөл дээрх итгэмжлэлийн сан гэсний итгэмжлэлийн гэсэн хасаад оруулах саналтай байна. Нэрийн хувьд ТУЗ дээр дахин ярилцахаар оруулъя.

САНАЛ ХУРААЛТ:

Санал өгөх санамжийг танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт 2 минут үргэлжлэв. 5 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа: Булигаар Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Санал хураалтын дүнг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Санал хураалтаар 51.63 хувийн саналын эрхтэй 206,631,000 ширхэг хувьцааны 3 ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

Хоёр. Компанийн байранд 36.48 хувийн саналын эрхтэй 145,996,000 ширхэг хувьцааны 1 ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.

Гурав. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гүйлгээнд гаргах тоог тогтоох, ТУЗ-д эрх олгох тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

<i>Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо</i>					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,627,000	100%	0	0%	0	0%

Дөрөв. Компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ батлах, хувьцааны тоог тогтоох тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

<i>Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо</i>					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,627,000	100%	0	0%	0	0%

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Ю.ДҮГЭРМАА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД

Д.ЭНХЗУЛ
Б.САРУУЛ

Хурлын дарга А.Энхмэнд: За баярлалаа. Одоо хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулна.

**Компанийн зарласан хувьцаанаас
гүйлгээнд нэмж гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 33 дугаар зүйлийн 33.3, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7.7.3 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Компанийн нэмж гүйлгээнд гаргах энгийн хувьцааны тоог 140'000'000 (нэг зуун дөчин сая) хүртэлх байхаар тогтсугай.

Хоёр. Компанийн гүйлгээнд нэмж гаргах энгийн хувьцааны тоо, нийтэд санал болгох үнэ, хугацаа, хувьцаа нэмж гаргахтай холбоотой аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллахыг эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.

**“Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”
(ESOP) батлах тухай**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Компанийн “Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” (ESOP)-ийг хавсралтаар баталсугай.
- Хоёр. Хөтөлбөрийн дагуу хуулийн этгээдийн бус сан байгуулах, сангийн үйл ажиллагааны журам гаргаж батлах, санд компаниас оруулах хөрөнгийн хэмжээг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл /А.Энхмэнд/-д зөвшөөрсүгэй.
- Гурав. “Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-т хамрагдах ажилтнуудын урамшууллын хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Хурлын дарга А.Энхмэнд: Энэ удаагийн ээлжит бус хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүд та бүхэндээ баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хаасныг мэдэгдье.

Хурал 14 цаг 35 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:

А.ЭНХМЭНД

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Ц.МӨНХЛХАГВА

